

Огноо: 2016.05.20

№: 008/16



Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж танаа

Дэлхийн Загасны Нүүдлийн өдрийг¹ тохиолдуулан Танд хандан Байгалийн шивэр хилэм загас буюу *Acipenser baerii baicalensis*-ийн өмнөөс Хил хязгааргүй гол мөрөн эвсэл энэхүү захидлыг илгээж байна. Байгалийн хилэм нь нэн ховор зүйл загас бөгөөд зөвхөн ОХУ, Монгол улсын хил дамнан орших Байгал нуур-Сэлэнгэ мөрний сав газар дагуух голуудад амьдардаг ба Монгол улсын Улаан ном, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцийн 2-р хавсралт болон бусад олон улсын жагсаалтанд орсон байдаг юм. Хилэм, мөн бусад Байгал нуур-Сэлэнгэ мөрний сав газар амьдардаг ач холбогдол бүхий тул (*Hucho Taimen*), Монгол омуль (*Coregonus migratorius*) зэрэг загасны оршин тогтнох эсэх нь Монгол, ОХУ хамтарч ажиллаж чадах эсэхээс хамаарах болоод байна. Өөрийн экологийн ач холбогдлоос гадна нүүдлийн загас нь ард иргэдэд загасчлах аялал жуулчлал эрхлэх, хүнсэнд хэрэглэх зэрэг уламжлалт хэрэглээтэй. Бонны конвенцэд нэгдэн орсон учир Монгол улсынхаа хамгийн том цэнгэг усны экосистемд тооцогдох Сэлэнгэ мөрний нүүдлийн загас хамгаалах боломж нээгдэж байгаа юм.

Дэлхий даяар усны далан барих төслүүд нь томоохон голуудын байгаль экологийн нэгдмэл байдалд аюул учруулж загас устах, загасны аж ахуйн үйл ажиллагааг бууруулах гол хүчин зүйл болж байна. АНУ-ын загасны аж ахуйн нийгэмлэг 2016 оны Дэлхийн нүүдлийн загасны өдрийг зарлахдаа Монгол улс Сэлэнгэ мөрөн дээр төлөвлөгдөж буй даланг барьснаар дэлхийд гайхагдах Хөвсгөл, Байгал нууруудын хүйн холбоог таслах болно хэмээн тодотгожээ². Үүнд нэн ховор, түүнчлэн эдийн засгийн ач холбогдол бүхий загасны зүйлүүдийн үржих орчинг устгаж, нүүдэллэх замыг хаах Эгийн гол, Сэлэнгэ мөрөн, Орхон гол дээр барихаар төлөвлөгдөж буй гурван том далангийн төсөл багтаж байна. НҮБ-ын ХХАА-н байгууллагын шинжээчдийн дүгнэлтээр Эгийн голын цахилгаан станц баригдсанаар загасны амин чухал амьдрах орчин устах аюултай учир дахин хянах шаардлагатай гэж тогтоосон байна³.

2015 оны 7-р сард Дэлхийн Өвийн Хороо⁴ Эгийн голын цахилгаан станц болон бусад хоёр төслийн өргөн хүрээ бүхий сөрөг нөлөөллийн үнэлгээг дутмаг хийснийг тэмдэглэж, бүх талын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийж Дэлхийн Өвийн Хороогоор хянуулахаас нааш төслүүдийг эхлүүлэхгүй байхыг Монгол талд даалгасан

¹ <http://www.worldfishmigrationday.com/events/756/fish-migration-day-in-mongolia>

² <http://fisheries.org/2016/05/third-annual-world-fish-migration-day/>

³ <http://www.fao.org/3/a-i4814e.pdf>

⁴ <http://whc.unesco.org/en/decisions/6279>

Зохицуулагч:


Оросын Холбооны Улс: Alexander Kolotov, Plotina.Net! • 660017 Krasnoyarsk, P.O. Box 6066, Утас +7-913-527-7440
Хятад: Zhang Yadong, Green Longjiang • Room 202, Flat 3, Building No. 14, Xin Xin Yi Yuan, Songbei District, Harbin 150028
Монгол Улс: Д.Сүхгэрэл, Оюу Толгойн Хяналт ТББ • УБ хот, СБД, Бага Тойруу, 44-6, Утас 976-98905828, duskhaerel@gmail.com
Америкийн Нэгдсэн Улс: Dr. Kristen N. McDonald, C Miraflores Ave., San Rafael, CA 94901 +1 510-859-5841, +86 18701215154;
kmcdonald@pacificenvironment.org, Олон Улсын: Eugene Simonov • Утас +86-13942868942, coalition@riverswithoutboundaries.org

билээ. Үүнийг үл харгалзан 2015 оны 11-р сард БНХАУ-ын Гэчжоуба Интернэшнл компанид Эгийн гол дээр барилгын ажлыг эхлүүлэх даалгавар өгсөн байдаг.

Монгол улсын эрх баригчдад хандан нүүдлийн загас судлах, хамгаалах бүхий л арга хэмжээ авахыг эрмэлзэж, энэхүү арга хэмжээнүүдийг авахаас нааш том хэмжээний далан барих төслүүдэд зөвшөөрөл өгөхгүй байхыг уриалж байна. Ялангуяа Бонны Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах конвенцын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, мөн ОХУ-тай хамтран нүүдлийн загас хамгаалах, мониторинг хийх, загасны аж ахуйн менежментийн үйл ажиллагаа явуулах хил дамнасан гэрээ байгуулах ажлыг эхлүүлэхийг уриалж байна.

Бонны конвенцын хэрэг эрхлэх газар хандан Байгалийн шивэр хилэм болон бусад Сэлэнгэ-Байгал нуурын сав газар амьдардаг нүүдлийн загасны зүйлийг хамгаалахад туслалцаа үзүүлэхийг хүсч байна.

Дэлхийн загасны нүүдлийн баярын мэнд хүргэж өнөөдөр болоод хойч ирээдүйд нүүдлийн зам нь саад тотгоргүй байхыг ерөөе!



ДУГ ЭРСҮРЭНГИЙН СҮХГЭРЭЛ,

Хил хязгааргүй гол мөрөн эвслийн Монгол дахь зохицуулагч

ЕВГЕНИЙ СИМОНОВ,

Хил хязгааргүй гол мөрөн эвслийн Олон улсын зохицуулагч

АЛЕКСАНДР КОЛОТОВ,

Хил хязгааргүй гол мөрөн эвслийн ОХУ дахь зохицуулагч